



Монголын Үйлдвэрлэлийн Хөгжлийн Төлөө



Энэ дугаарт:

Nr. 1 / 2019

- Маркус Эппэр “Байгууллагын алсын хараа”
- Швейцарын бизнес аяллын тэмдэглэлээс
- “Зөрчлийн менежмент” сургалт
- Сургалтуудын хуваарь



Маркус Эппэр

ВРН Монгол салбарын үйл ажиллагаа хариуцсан захирал

“Байгууллагын алсын хараа” нь бизнесийг зөв удирдах хамгийн гол цөм нь юм. Алсын хараа нь тухайн бизнесийн ирэх 5-10 жилийг илэрхийлэх ирээдүйн зураглал бөгөөд зорилгodoо хүрэх замыг чиглүүлэгч “Алтан гадас” билээ.

Амжилттай яваа бизнес эрхлэгчид нь алсын хараагаа тодорхойлон, түүнээс үүдэн зорилгоо урт хугацаанд төлөвлөн ажилладгаараа бусдаас ялгардаг.

Баг хамт олны хамтын шийдвэр нь хамт олны дунд хүлээн зөвшөөрөгдөх байдал, үзүүлэх нөлөөгөөрөө илүү байдаг. Иймд ВРН-ийн зүгээс хөтөлбөрийн оролцогчдодоо зориулан “Байгууллагынхаа алсын хараа”-г хамт олонтойгоо хамтран тодорхойлох, түүнийг байгууллагад хэрхэн амьдруулах талаар багийн сургалтыг санал болгож байгаа билээ.

Бид багийн сургалтыг хөтөлбөрийн оролцогчдын захиалгын дагуу ажлын байран дээр нь очиж зохион байгуулан бүх ажиллагсдыг хамруулдаг. Энэ нь ажиллагсадтайгаа хамтран алсын хараагаа тодорхойлох, байгууллагынхаа үнэт зүйлийг бий болгох, түүнийг байгууллагад суулгаж өгөх зорилготой юм.

Бизнес эрхлэгч та урд удаан хугацаанд бизнесээ “АЛСЫН ХАРАА”-тай, амжилттай удирдан явуулах хүсэлтэй байвал бидэнд хандаарай. ВРН-ийн зүгээс та бүхэнтэй хамтран ажиллахдаа таатай байх болно.

“Хaa хүрэх зорилгоо мэдэхгүй нэгэн хаана байгаагаа гайхах хэрэггүй”
Марк Твейн

Мэдээ, мэдээлэл

“Зөрчлийн менежмент” сургалт

Аливаа харилцаанаас их бага хэмжээгээр зөрчил үүсч байдаг. Зөрчилд хэрхэн хандах хандлага нь бидний цаашдын ажлын амжилт, гэр бүлийн харилцаа, эрүүл мэндэд нөлөөлж байдаг билээ. Зөрчлийн үед хувь хүмүүс өөр өөр хариу үйлдэл үзүүлдэг бөгөөд хүндээр хүлээн авдаг нэгэн байхад зөрчлөөс зайлсхийдэг, зөрчилд тэсвэртэй нэгэн байх нь бий.

Түүнчлэн зөрчлийн явцад бүтээлч сэтгэлгээ, шинэ санаанууд дэмжигдэн гарч, өрсөлдөөн болон өөрчлөлт бий болдог сайн талтай.

Манай байгууллагын зүгээс сургалтын хөтөлбөртөө нэмэлтээр “Зөрчлийн менежмент” сургалтыг Швейцар эксперт Ханс Вилхэлмийн удирдлага дор шинээр зохион байгуулж эхэллээ. Уг сургалт нь зөрчлийг таньж мэдэх, түүнийг оновчтой удирдан явуулах арга зүйг жишээн дээр тулгуурлан явуулдаг нь сургалтад оролцогчидод онцгой сургалт боллоо.

Хөтөлбөрийн оролцогч Д.Биндэрья “ХОС БЭХИ” ХХК

Зөрчлийг яаж эерэгээр шийдэх вэ? гэдэг нь миний хувьд маш хүнд асуудал, маш хүнд сэдэв байсаар ирсэн. Зөрчлийн менежмент сургалтад сууснаар асуудлыг олон талаас нь харж сурах, ингэснээр зөв, ээрэг гарцыг олж харах арга замд суралцаа. Сургалтыг зохион байгуулсан ВРН-ийн хамт олон болон Ханс багш, Эрдэнэсүрэн нартаа маш их баярлалаа.



Б.Энхзул BPN нийгэмлэгийн гишүүн

“Инноваци бол бидний амжилтын жор юм”

Hugentobler Schweizer Kochsysteme AG

“Намайг Б.Энхзул гэдэг. 2011 оноос хойш “Алтан элч” ХХК-ийг үүсгэн байгуулж, гадаад худалдаа, сургалт, нийтийн хоолны салбарт үйл ажиллагаа эрхэлж байна. Миний эрхэлж буй салбарын үйл ажиллагаатай холбоотой учир Швейцарын Hugentobler компанийн бүтээгдэхүүн, менежментийг сонирхон судалж байлаа. Аав Р.Баттөмөр маань BPN-ийн өнгөрсөн жилийн бизнес аялалд хамрагдаж ирээд мэдээлэл өгснөөр уг үйлдвэртэй өөрийн биеэр очиж танилцах боломж олдсон юм.

Аяллын хөтөлбөр, үйл ажиллагаа эхнээсээ аваад дуусах хүртлээ маш сайн зохион байгуулалттай байсан бөгөөд орчуулга болон бусад үйлчилгээ шуурхай, тав тухтай байсныг онцолмоор байна. Нийт 4 өдрийн хугацаанд 8 үйлдвэрээр (Recycling Paradise-хог хаягдал боловсруулах үйлдвэр, Hugentobler Schweizer Kochsysteme AG-нийтийн хоолны тоног төхөөрөмжийн үйлдвэр, Reinhart AG —талх, нарийн боовны үйлдвэр, Primarschule Köniz-Buchsee-ерөнхий боловсролын дунд сургууль, BPN-ийн төв оффис, Strickerei Textil AG-сүлжмэл эдлэлийн үйлдвэр, Victoryupoх-хутганы үйлдвэр, 4B Holding AG-вакум цонх, фасадны үйлдвэр) зочилж, бизнесийн удирдлагын онцлог, үйл ажиллагаатай танилцаж, сонирхсон асуултууддаа хариулт авч явлаа. Бидний зочилсон бүх компаниуд найрсаг зочломтгой хандаж, компанийн удирдлагууд өөрийн биеэр хүлээн авч, танилцуулга хийсэн нь хүндэтгэлтэй бөгөөд ач холбогдолтой болсон.

Энэхүү бизнес аялал надад Швейцар компаниудын бизнесийн өөр өөрийн онцлог, хөгжил, дэвшилтэт технологи, удирдлага болон хүний нөөцийн менежментийг судлах, суралцах ховорхон боломжийг олгож чадсан юм. Бүх аж ахуйн нэгжүүд өөр өөрийн онцлог, бахархах түүхтэй, ажилчдаа дэмжсэн бодлоготой нь маш их таалагдлаа.

Ялангуяа Victoryupoх-хутганы үйлдвэрийн хүний нөөцийн бодлого, ажилчдын урамшууллын систем, идэвхижүүлэлтийн бодлого, тэр дундаа ажилчиддаа зориулсан банкны үйл ажиллагаа, ажилчдын хүүхдэд олгодог хүүхдийн мөнгө, эрүүл мэндийн хөтөлбөрүүд нь өөрийн компани дээр хэрэгжүүлэх санаанууд байлаа.

Мөн мэдээж Hugentobler компанийн бүтээгдэхүүний инноваци нэвтрүүлсэн байдал, үйлдвэрийн үнэт зүйлүүд нь өндөр сэтгэгдэл үлдээж чадсан.

Мэргэжлийн хүний хувьд би Монголын хоцронгуй байгаа хоол үйлдвэрлэлийн салбарт инноваци нэвтрүүлэх зорилготой байсан ба юу хийх арга, техникээ олохгүй өнөөдрийг хүрсэн. Харин “Тогооч нарын диваажин” уриатай бүтээгдэхүүн нэвтрүүлж, тэдгээр нь хүний эрүүл мэнд, хүнс үйлдвэрлэлийн салбарт шинэ техник нэвтрүүлэх боломжийг Hugentobler үйлдвэрээс хараад эх орондоо нэвтрүүлэхийг зорьж, хамтын ажиллагаагаа эхлүүлэх эхний алхмаа хийсэндээ баяртай байна.



Сургалтуудын хуваарь



Цагийн менежмент 2019.09.27-09.28 /2 өдөр/

Агуулга:

Цаг төлөвлөлтийн 10 дүрэм, цаг төлөвлөлтийн чухал хэрэгслүүд болох дэвтэр болон цахим хуанлитай дэлгэрэнгүй танилцааж, тэдгээрийг зөв ашиглах арга барил эзэмшинэ. Мөн сургалтын оролцогч бүр үйл ажиллагаандaa уялсан хувийн төлөвлөгөө гаргах ба цаашид ажил, амралт чөлөөт цагаа зөв төлөвлөн зохион байгуулж стрессгүй, тэнцвэртэй амьдарснаар амжилт таны гарт ирэх болно.



Төслийн менежмент 2019.11.13-11.15 /2 өдөр/

Агуулга:

Үйл ажиллагаа нь амжилттай явагдаж байгаа компани бүрт төсөл хэрэгжиж байдаг боловч тэдгээр нь мэргэжлийн түвшинд хэрэгжиж байна уу үгүй юу гэдгээрээ ялгардаг. Сургалтаар төслийн үе шатууд, асуудлыг шийдвэрлэх арга зам, бүтээлч арга барил болон төслийн төлөвлөлт, удирдлагын аргуудтай танилцах, оролцогчид тэдгээрийг хэрэглэж сурхадаа чадвар эзэмшихэд оршино.



Хамт олноо удирдахуй 2019.11.18-11.20 /3 өдөр/

Агуулга:

Удирдагчийн үндсэн зарчмууд: хариуцлага, мотиваци, бүтээлч сэтгэлгээ, алсын хараа ба зорилго, удирдлагын мэдээлэл боловсруулалт, удирдлагын харилцаа, зөв шийдвэр гаргах, ажилтнуудтай хийх уулзалт, ур чадварын үнэлгээ, хувь хүний зан чанар ба хүнийг таних чадвар, DISG зан чанарын загвар, хувь хүний зан чанарт тохицуулан харьцах, хэлэлцүүлгийг үр дүнтэй явуулж, багаар ажиллах нь гэх мэт.



Сургалт болон хөтөлбөрийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг манай вэб хуудаснаас авна уу.

WWW.BPN.MN



Хаяг:

СБД, 8-р хороо, Оюутны 33
"ТАНАН" төв, 404 тоот

Утас:

77113309, 70113309

Эшуудан: info@bpn.mn